



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 70

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Бөмбөгөр сумын ИТХ-ын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад Аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын хорооны 2017.11.07-ны шийдвэрийг үндэслэн сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017.11.25-ны өдрийн 18 тоот хурлын тэмдэглэлээр С.Баатарт арга хэмжээ авах шийдвэр гарсан байна. Дээрх шийдвэрийн дагуу Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын 2017.12.19-ны өдрийн 08 тоотоор сахилгын арга хэмжээ авсан атлаа 2017.12.19-06 тоот тушаалаар 300.0 мянган төгрөгийн урамшуулал олгосон байна

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэлийн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан” зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

D:\2018 on akt\Bumbugur sumiin ITH\_akt .docx

2518021

1. Төсвөөс зориулалт бусаар олгосон 270000 /Хоёр зуун далан мянга/ төгрөгийг С.Баатараар төгрөгийг төлүүлж Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг

Бөмбөгөр сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Мэндбаяр, нягтлан бодогч Ж.Гандалай нарт хариуцуулав.



АКТЫГ

ТОГТООСОН<sup>1</sup>:

АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ



ЗӨВШӨӨРСӨН:

БӨМБӨГӨР СУМЫН ИТХ-ЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА  Б.МЭНДБАЯР  
НЯГТЛАН БОДОГЧ 



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 12 сарын 25 өдөр

Дугаар 78

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянговь сумын ЗДТГ-ын төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад

1. Баянговь сумын ЗДТГ-ын даргын 2017.12.15-ны 53 тушаалаар сахилгын шийтгэлтэй 2 ажилтанд 600.0 мянга, Аймгийн ЗД-ын шийдвэр гараагүй байхад сумын Засаг дарга Б.Эрдэнэбилэгт 300.0 мянган төгрөгийг олгосон.
2. СХБ дэмжих төвд номны үнэ 20.0 мянган төгрөг илүү төлсөн.
3. Нэмэлт санхүүжилтийн дансанд ОНХС-д төвлөрөх өвсний үнийг оруулан 5496,0 мянган төгрөгөөр өвс тэжээл худалдан авч үлдэгдэл 124.0 мянган төгрөгийг ОНХС-д төвлөрүүлээгүй байна.

Дээрх зөрчил дутагдал гаргасан нь Монгол Улсын Их Хурлын 2017 оны “Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 67 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны “Урамшуулал олгох тухай” 52 дугаар тэмдэглэл, НББ-ийн тухай хуулийн 14.4.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан “Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам”-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь “...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад

D:\2018 on akt\Bayangobi sumiin ZDTG\_akt .docx

2518037





нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү төлсөн номны үнэ 20,0 мянган төгрөгийг сумын ИТХ-аас суутган тооцоо хийж, зориулалт бусаар олгосон 810,0 мянган төгрөгийг холбогдох хүмүүсээр төлүүлж нийт 830,0 мянган төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Нэмэлт санхүүжилтэд төвлөрүүлсэн өвсний үнийн үлдэгдэл 124,0 мянган төгрөгийг Сумын ОНХС-д төлүүлэх.

3. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянговь сумын ЗДТГ-ын дарга Д.Отгонжаргал, нягтлан бодогч Э.Пүрэвжаргал нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН <sup>1</sup> :	ЗӨВШӨӨРСӨН:
АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ	БАЯНГОВЬ СУМЫН ЗДТГ-ЫН ДАРГА  Д.ОТГОНЖАРГАЛ НЯГТЛАН БОДОГЧ  Э.ПҮРЭВЖАРГАЛ

<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2018 оны 02 сарын 25 өдөр

Дугаар 80

Номгон

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлд тодорхойлсон Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Баянлиг сумын ЕБС-ийн төсвийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөвлөсөн горим сорилыг хэрэгжүүлэх явцад:

1. Сургуулийн Үдийн цай хөтөлбөрт хамрагдсан нэг хүүхдэд ногдох дундаж нормативаар санхүүжүүлэх зардлын гүйцэтгэлийг хүүхэд-өдрөөр хянаагүйгээс сургуулийн жижүүр багшийн хүүхдийн ирц үдийн цайнд хамрагдсан хүүхдийн ирцээс 1, 2-р сард хүүхдийн тоо 197 хүүхэд өдрөөр зөрүүтэй тооцож Их халбаганат ХХК-нд 118.2 мянган төгрөгийг илүү олгожээ.

Энэ нь Засгийн газрын 2012 оны 106 тоот "Хоолны зардлын дундаж норматив батлах тухай" тогтоолын 4 дэх заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх..., Монгол улсын Ерөнхий аудиторын 2016 оны А/95 тоот тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын акт тогтоох, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3 дугаар зүйлийн 3.1.7 дахь "...төлбөрийн акт тавих үндэслэлтэй бусад нөхцөл байдал гаргасан" зөрчилд төрийн аудитын байгууллага төлбөрийн акт тогтооно гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Илүү олгосон 118200 / Нэг зуун арван найман мянга хоёр зуун/ төгрөгийг Баянхонгор аймгийн Төрийн сан дахь бусад, татвар хураамжийн орлогын 10003000947 тоот дансанд төвлөрүүлэх.


D:\2018 on akt\Bayanlig sumiin EBS\_ akt.docx



2518041



2. Төлбөрийн актыг бүрэн барагдуулж, санхүүгийн баримтыг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Баянлиг сумын ЕБС-ийн захирал С.Цэдэндорж, нягтлан бодогч Т.Ганхүлэг нарт хариуцуулав.

АКТЫГ

ТОГТООСОН<sup>1</sup>:

АХЛАХ АУДИТОР  А.ЦЭЭНЯМ

Баянлиг сумын ЕБС-ийн  
ЗАХИРАЛ  С.ЦЭДЭНДОРЖ  
НЯГТЛАН БОДОГЧ  Т.ГАНХҮЛЭГ



<sup>1</sup> Акт, албан шаардлагын биелэлт хангагдаагүй тохиолдолд Төрийн аудитын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.2-д заасан "Төрийн аудитын байгууллагаас тавьсан албан шаардлага, төлбөрийн актыг цаг хугацаанд нь биелүүлээгүй тохиолдолд зөрчил гаргасан албан тушаалтныг үүрэгт ажлаас нь халах тухай саналыг төрийн аудитын байгууллага эрх бүхий албан тушаалтанд хүргүүлнэ" гэж заасны дагуу хариуцагч албан тушаалтанд хариуцлага ногдуулахаар эрх бүхий албан тушаалтанд санал хүргүүлнэ.